



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/13

Хажуу шенэ үс

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих багш нарын байрыг засварлах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Гишүүд: Э.Дүүрэнжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)
Г.Мөнхбаясгалан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн)
Э.Энхжаргал (Иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

2.Тендер шалгаруулалтыг хууль журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Уянга)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.АРИУНАА

482301013